

23. Бурхан минь, Есүсийг дагадаг Балбын эмэгтэйчүүдэд амар амгалан, хүч чадал, хангамжийг өгөөч. Зарим нь үл итгэгч нөхрүүддээ хавчигдаж, гэрээсээ хөөгдөж байна. (1 Петр. 3:14)

24. Эзэн минь, хүүхдүүдийнхээ хэрэгцээг хангахын тулд шаргуу ажилладаг Филиппин ганц бие эхчүүдийг дэмжиж, тайвшруулаарай. Хүүхдүүдээ хүмүүжүүлж, удирдан чиглүүлэх мэргэн ухааныг тэдэнд өгөөч. (Исаиа 41:10).

25. Бурхан минь, Солонгос улс 2 хуваагдаж байх үед бие биенээсээ салсан гэр бүлүүдийг эвлэрүүлж өгөөч гэж бид залбирч байна. Тэднийг биечлэн эсвэл захидал хэлбэрээр дахин нэгтгэх арга замыг зааж өгнө үү. (2 Коринт 13:11)

26. Эзэн минь, Энэтхэгийн эмэгтэйчүүдэд хүчирхэг залбиралтай амьдрах хүслийг өгөөч. Царт тахлын үед TWR "Найдвар доторх Эмэгтэйчүүд" төслийн залбирлын багт оролцсон олон хүмүүст баярлалаа. (Еф. 6:18)

27. Аав аа, Камбожийн эмэгтэйчүүд таны хайрыг хүлээн зөвшөөрч, танаас хамааралтай болж сурахад тэдний итгэлийг бэхжүүлээч. (Евр. 11:6).

28. Бурхан минь, Индонези дотроос хөрөнгө босгож өгөөч, ингэснээр сайн мэдээний багийн дагалдагч нар сонсогчидтой ойр дотно харилцаа тогтоож, тэдний таны талаарх итгэл, мэдлэгийг нэмэгдүүлэхэд нь туслах болно. (2 Тес. 1:3). (2 Тес. 1:3)

29. Эзэн минь, Хятадад худалдаалагдсан тоо томшгүй олон эмэгтэйчүүд, охидыг эдгээж, эдгэрэхийн төлөө бид залбирч байна. Энэ бузар мууг арилгахын тулд зөв шударга удирдагчдыг гаргаач. (Иер. 30:17).

30. Бурхан минь, бага насны хүүхэдтэй Вьетнам ээжүүдийг гэрийн ажил хийж, хүүхдүүдээ асран, хоол унд бэлдэж байхад нь тэднийг хүчирхэгжүүлээрэй. (Исаиа 40:31).

31. Монголын өрх толгойлсон эхчүүд таны хүч чадал, амар амгалан байдалруу оюун ухаанаа чиглүүлэх болтугай, Аав аа. Тэд танд хүнд ачаагаа үүрүүлж, танаас



**Найдвартай
эмэгтэйчүүд**

Сар бүр гаргадаг "Найдвартай эмэгтэйчүүд" залбирлын хуанли
100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа
залбирч байна.



2022. 08.

Азийн эмэгтэйчүүдэд зориулсан залбирал

Индонез бол Есүсийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү 50 орны нэг юм. "Найдвар доторх Эмэгтэйчүүд" хөтөлбөр нь сонсогчдод Бурханы үгийг аюулгүйгээр сонсох боломжийг олгож байна. Энэтхэгийг мухар сүсэгт автсан эмэгтэйчүүдийн төлөө, Балбын эмэгтэйчүүдийн албадан биеэ үнэлэлт, хүчирхийлэл болон нөхөр нь олон эхнэр авснаас болж зовж шаналж буй эмэгтэйчүүдийн төлөө, Филиппиний хөдөө тосгонд гэр бүлийн хүчирхийлэл, эдийн засгийн хүндрэлд өртөж буй эмэгтэйчүүдийн төлөө, хүчирхийлэлд өртөж, боловсрол эзэмшиж чадахгүй, ажил олоход бэрхшээлтэй байгаа Камбож эмэгтэйчүүдийн төлөө залбирч өгөөч! Бурханд хандсан таны залбирал эдгээр эмэгтэйчүүдэд хүрч үйлчлэн гэдэгт бид итгэлтэй байна.

TWR Women of Hope

<https://www.twrwomenofhope.org>

E-mail: phkorea@twrk.or.kr

1. Эзэн минь, Японы ард түмний итгэлгүй байдлын гинжийг таслаач. Тэндхийн сүм чуулганууд сайн мэдээг зоригтойгоор тунхаглаж, хүмүүсийн сүнс болон зүрхэнд сэргэлтийг авчирч, аврал руу хөтлөх болтугай. (Исаиа 55:6-7).

2. Бурхан минь, бид "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг дамжуулахын тулд Балбын дүүрэг бүрт FM радио станцтай болгож өгөхийг танаас гуйн залбирч байна. (Филиппой 4:9)

3. Эзэн минь, Та биднийг ЭЗЭНд баяртайгаар үйлчил гэж дууддаг билээ. Филиппиний охид эмэгтэйчүүдийг таны төлөө үйлчлэх Бурханлаг зүрх сэтгэлтэй болгож өсгөөч. (Дуу. 100:2)

4. Тэнгэрлэг Эцэг, таныг сонгосон эмэгтэйчүүдийг Монгол, Хятад, Тайвань, Хонг Конг дахь TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" үйл ажиллагааг удирдаж үйлчлэхэдилгээгээч гэж бид залбирч байна. (Иер. 6:8)

5. Ариун Бурхан минь ээ, Энэтхэгийн TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" сэтгүүлийн зохиолч, хөтлөгч, гишүүд тус бүрээр дамжуулан ажиллаач. Эмэгтэйчүүдийг Есүс рүү авчрахын тулд тэдний бэлэг, авьяасыг ашиглаач. (1 Петр 4:10)

6. Эзэн минь, Камбожийн залуучуудыг хар тамхины наймаанд ашигладаг хүмүүсээс хамгаалаач. Эдгээр оюутнуудад хар тамхи нь тэдний оюун ухаан болон ирээдүйг сүйрүүлнэ гэдгийг ойлгуулж өгөөч! Оронд боловсролдоо анхаарахад нь туслаач. (2 Тесалоник 3:3).

7. COVID-19 тахлын үед Индонезид эмэгтэйчүүдийн эсрэг бие махбод, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийллийн хэрэг нэмэгджээ. Аав аа, эдгээр эмэгтэйчүүд танаас аврал, эдгэрэлт, итгэл найдварыг олох болтугай. (2 Коринт 9:8)

8. Богино долгионы болон дижитал радиогоор цацагддаг "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг Хятад хэлээр дамжуулж байгаад Бурхан Таныг магтъя. Олон хятадууд эдгээр нэвтрүүлгийг сонсож, Есүст итгэл, найдвараа тавих болтугай. (1 Кор. 15:3)

9. Эзэн минь, Вьетнамд 3 эмэгтэйн тутмын 1-н нөхрөөсөө бие махбод, сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг, Тэдгээр эмэгтэйчүүдийг хамгаалж, Зүрх сэтгэлийн эдгээгээч. (Дуу. 107:19–21)

10. Эзэн минь, Сингапурын ажил болон гэр бүлийн үүрэг хариуцлагаа биелүүлэхийн төлөө тэмцэж буй эмэгтэйчүүдэд хүч чадал, шийдэмгий байдлыг өгөөч гэж бид залбирч байна. (Дуу. 28:7)

11. Аав аа, Монголын архидалтын цайзыг эвдээч. Архинд донтсон хүмүүсийг донтолтоос нь чөлөөлж ажилтай болгож, гэр бүлээ тэжээх болтугай. (Дуу. 107:14)

12. Аав аа, COVID19 цар тахлын үед Япон хүүхдүүдийг айдас, ганцаардлаас хамгаалаач. Тэднийг халдварт өвчнөөс хамгаалж, таны сайн мэдээг сонсох боломжийг олгооч. (Дуу. 90:6).

13. Бурхан минь, Балбын TWR байгууллагын "Найдвар доторх Эмэгтэйчүүд" төсөл нутгийн эмэгтэйчүүдэд бичиг үсгийн сургалт явуулдаг тул оролцогчдод Библи уншиж, бичиж, банкны дансандаа гарын үсгээ зурж сурах болтугай. (Ром. 3:12)

14. Аав аа, та бол бидний эдгээгч! Хүчирхийлэлд өртсөн Филиппин эмэгтэйчүүдийн зүрхний шархыг эдгээгээч. Тэднийг нийгэмд үнэлж, хүндэтгэж, сэргээн босгох болтугай. (Дуу. 51:17)

15. Эзэн минь, бид Хойд Солонгосоос өмнө зүгт гаталж ирсэн 25,000 эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Төрийн халамжийн бодлого ч, сүсэгтэн олон ч эдгээр эмэгтэйчүүдэд сайн үйлчилж, тусалж байгаасай. (Дуу. 145:9).

16. Аав аа, 2022 оны 4-р сараас эхлэн Ориа, Гужарати, Тамил хэлээр "Найдвар доторх Эмэгтэйчүүд"-хөтөлбөрийг телевизээр гаргаж эхэлсэн билээ, нэвтрүүлгээр дамжуулан эдгээр эмэгтэйчүүдийн амьдралыг өөрчлөөч (2 Кор. 3:18).

17. Бурхан минь, Камбож дахь TWR "Найдвар доторх Эмэгтэйчүүд"-ийн үйлчлэлийг хөгжүүлэх туслаач. Эдгээр хөтөлбөр, үйлчлэлээр дамжуулан олон эмэгтэйчүүд таныг таньж мэдэн, дагах болтугай. (Дуу. 25:5)

18. Индонезийн эмэгтэйчүүд ядуу зүдүү амьдарч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байна. Ихэнх эмэгтэйчүүд нь умайн хүзүүний хорт хавдар, хөхний хорт хавдар зэрэг эрүүл мэндийн ноцтой асуудалтай байна. Эзэн минь, зовж зүдэрч байгаа хүмүүст эдгэрэлтийг өгөөч. (Иер. 17:14).

19. Аав аа, Хятадад нэг хүүхдийн бодлого зогссон ч, үр хөндөлт, нялх хүүхэд хөнөөх явдал зогсоосой гэж залбирч байна. (Дуу. 139:13–16)

21. Тэнгэрлэг Эцэг ээ, жирэмсэн болон хүүхэд өсгөж буй Япон эмэгтэйчүүд гэр бүл, засгийн газраасаа шаардлагатай дэмжлэгийг авч, сайн мэдээг сонсож, хүлээн аваасай гэж бид залбирч байна. (Дуу. 71:6).

22. Олон монгол эмэгтэйчүүд нийслэл хотруугаа ажил хайн гэрээсээ явдаг. Эзэн минь, эдгээр эмэгтэйчүүдэд сайн ажил олж өгч, тэднийг ажил олгогчийнх нь хор хөнөөлөөс хамгаалаарай. (Дуу. 23)